



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 1133

Шивээговь сум

Малчдад цол тэмдэг олгох, хүндэтгэл
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.4, 3.1.4, 5.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгой өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж сумын “Аварга малчин”-аар Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Даваасамбуугийн Дашзэвэг, сумын “Алдарт уяач”-аар Үржинбадамын Баяржаргал, Дэлгэрсайханы Нямдаваа, Болдсайханы Сүх-Эрдэнэ, Нямхүүгийн Цэлмэг нарыг шалгаруулж цол, тэмдгийг тус тус олгосугай.

2.“Улсын Аварга малчин”-аар шалгарсан Чинбатын Амартүвшин, Волоожийн Оюундэлгэр нарт хүндэтгэл үзүүлэн, дурсгалын үнэ бүхий зүйлээр урамшуулсугай.

3.Шагнал, урамшуулалд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

4.Шагналд зарцуулагдах 3,621,300 (гурван сая зургаан зуун хорин нэгэн мянга гурван зуу) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), Ахлах нягтлан бодогч (Л.Туяа) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42125 1 0

Сумын Засаг даргын 2025 оны 02-р
сарын 20-ны өдрийн 1/33 дугаар
захирамжийн хавсралт



УЛСЫН АВАРГА МАЛЧИН, СУМЫН АВАРГА МАЛЧИН,
АЛДАРТ УЯАЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2025.02.20

№	Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сумын аварга малчны малгай, залаа, тэмдэгтэй	1	304,300	304,300
2	Улсын Аварга малчны талархал, сумын Аварга малчны өргөмжлөл	2	135,000	270,000
3	Сумын Алдарт уяачийн малгай	4	166,500	666,000
4	Сумын Алдарт уяачийн энгэрийн тэмдэг	4	27,500	110,000
5	Өргөмжлөл	4	71,500	286,000
6	Хадаг	6	5,000	30,000
7	Дагалдах мөнгөн шагнал /сумын "Аварга малчин өрх"	1	200,000	200,000
8	Дагалдах мөнгөн шагнал /сумын "Алдарт уяач"	4	100,000	400,000
9	Улсын "Аварга малчин өрх"-д хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг	1	1,155,000	1,155,000
10	Сумын Алдарт уяачдад хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг	4	50,000	200,000
Нийт				3,621,300

----- ооо -----